*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ДОРНОД АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН САНХҮҮ БҮРТГЭЛ, ХАМРАЛТ, ОРЛОГЫН ХЭЛТСИЙН ХАМРАЛТ ОРЛОГО ШИМТГЭЛИЙН ӨР ХАРИУЦСАН БАЙЦААГЧ М.ЭНХЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ***Нэг. Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх, өр авлага барагдуулах, нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тооцоотой холбоотой мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг хянах, тайлагнах*** | | | | | | | |
| 1. | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын хуульд заасан хугацаанд төлүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах; | Орлогын төлөвлөгөөний хувь | 19,459,735.9 мян.төг 100 хувь. | 26,040,763.5 мян.төг 100 хувь. | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төлөвлөгөө 26,040,763.5 мян.төг төгрөг төвлөрүүлэхээс жилийн эцсийн байдлаар 513 аж ахуй нэгжийн 30,124,311.3 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 115.6 хувь биелүүлэн ажилласан байна. | 2024.01.01 - 2024.12.30 | 100 |
| 2. | “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил 2024” зорилтод жил болон сайн дурын даатгуулагчдын хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд | Орлогын төлөвлөгөөний хувь | 4838 | Сайн дурын даатгалд хамрагдсан ХХЭ, эхчүүдийн тоо бүрэн | Оны эхнээс хагас жил хүртэл аймгийн хэмжээнд нийт 3788 даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдсан. Үүнд:<br>- Малчин 1360, | 2024.01.01 - 2024.12.30 | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын талаар аж, ахуйн нэгж, иргэд даатгуулагч нарт мэдээлэл хүргэх, | | | биелүүлсэн байна | - Хувиараа хөдөлмөр эрхлэгч 515,<br>- 0-3 насны хүүхдээ асарч буй эх 579,<br>- Ажил хөдөлмөр эрхлээгүй болон бусад 1234,<br>- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эх, эцэг 82 хамрагдсан байна.<br><br>- Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын талаар<br><br>• Хүнс хөдөө аж, ахуйн газар<br>• Эрүүл мэндийн газар<br>• 3,10, 11 дүгээр багийн ажлын алба<br>• Аймгийн ахмадын холбооноос зохион байгуулсан нийт сумдын ахмадын холбооны дарга нарын нэгдсэн өдөрлөг<br>• Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэг зэрэг аж, ахуй нэгж байгууллагийн 100 гаруй ажилтан албан хаагчидад нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын талаар мэдээлэл хүргэж, асуултад хариулсан.<br><br>- Дорнод аймгийн жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих төвөөс зохион байгуулсан сургалтад хувираа гар урлал оёдол захиалга засварын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, цахим үйлчилгээ, нийгмийн даатгал | | | | үйлчилгээ эрхэлдэг 46 иргэнд мэдээлэл хүргэн 3 иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулсан.<br><br>- Монголын хуульчдын холбоо иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулан "Хуульчийн Про Боно өдөр" (хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа үзүүлэх өдөр)-ийг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулдаг. Арга хэмжээний үеэр 22 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч, гарын авлага, мэдээлэл тараасан.<br><br>- Ажилгүйдлийн тэтгэмж авахаар хүсэлт гаргасан иргэдийг 100 хувь сайн дурын даатгалд хамруулахаар зорилт тавин, тэтгэмжийн хүсэлт гаргасан даатгуулагч бүрд сайн дурын даатгалын ач холбогдол, хөнгөлөлтүүдийн талаарх мэдээлэл болон, /Portal.ndaatgal.mn/ цахимаар хэрхэн сайн дурын даатгалд даатгуулах талаар даатгуулагчийн гар утсанд нэвтрэн тайлбарлаж хүсэлтийг илгээлгэн сайн дурын даатгалд хамруулж байна. үүний үр дүнд 70 иргэнийг сайн дурын даатгалд хамаруулсан байна.<br><br>- Нийгмийн даатгалын үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх зорилгоор нэвтрүүлсэн "Нийгмийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аппликейшнийг сурталчлах, баталгаажуулах<br><br>“CALL PRO” үйлчилгээгээр хандсан иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх. “Дорнод Нийгмийн даатгал” пэйж хуудасны “Чат бот”-т хариу өгөх. | | | | даатгал” гар утасны аппликейшний ач холбогдлыг иргэдэд сурталчлан таниулах, хэрэглээг нэмэгдүүлэх, сайн дурын даатгалд цахимаар хамруулахаар 12 иргэний гар утсанд “Нийгмийн даатгал” аппликейшнийг суулган, баталгаажуулж, нууц дугаарыг олгосон байна. 19 иргэний майл хаягийг одоо ашиглаж байгаа майл хаягаар өөрчлөн цаашид нийгмийн даатгалын үйлчилгээг хэлтэст биеэр очилгүйгээр цахимаар авах нөхцлийг бүрдүүлсэн.<br><br>- Хэлтсийн лавлах утасны “CALL PRO” үйлчилгээгээр ирж буй дуудлага бүрд хариу өгч ажиллаж байна. Өдөрт энгийн үед 10-15 дуудлага, сар улирлын сүүлчийн өдрүүдэд ачаалал нэмэгдэн өдөрт 20-35 дуудлагад тогтмол хариу мэдээлэл өгч байна.<br><br>“CALL PRO” үйлчилгээгээр ирж буй дуудлагуудын асуултыг дурдвал сайн дурын даатгалын шитгэлийг цахимаар хэрхэн төлөх, сард хэдэн төгрөг төлөх, шимтгэл төлсөн сараа мартсан тул шалгуулах, регистрийн дугаараа буруу бичиж шимтгэлээ төлснөөс гарсан алдаанууд залруулах, дансны дугаар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Цахим хэлбэрээр ирүүлсэн ажил олгогчийн шимтгэл төлөлтийн (НД-7; НД-8) тайланг тайланг цаасан тайлантай тулган баталгаажуулах, | | | | тодруулах зэрэг асуултууд дийлэнх хувийг эзэлж байна.<br><br>8 дугаар сараас хойш ажлын байр өөрчлисөнтэй холбоотойгоор ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайланг хүлээн авч ажиллаж байна. Уг хугацаанд<br>• Баянуул сум – 33<br>• Баяндун сум - 31<br>• Булган сум – 21<br>• Гурванзагал сум – 15<br>• Матад сум – 18<br>• Чулуунхороот сум – 15<br>• Хэрлэн сум - 347<br>Байгууллага буюу нийт 513 аж ахуйн нэгж байгууллагын шимтгэл ногдуулалтын тайланг хүлээн авч, хянан баталгаажуулж ажилласан. | | |
| 3 | Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх, эсхүл эцгийг нийгмийн даатгалд хамруулах, | Төлөвлөгөөний биелэлт | 247 эх, эсхүл эцгийг нийгмийн даатгалд хамруулах, | 247 эх, эсхүл эцгийг нийгмийн даатгалд хамруулах, | Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран ажиллах гэрээ байгуулан Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх, эсхүл эцгийн судалгааг нууцын ажилтнаар дамжуулан авч ажиллав.<br>Судалгаагаар нийт 270 иргэний мэдээлэл ирсэн. Үүнээс:<br>- Ажил хөдөлмөр эрхэлж байгаа 95,<br>- Энгийн сайн дурын даатгалд 2,<br>- Малчин 1, | 2024.01.01<br>-<br>2024.12.30 | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэх | | | | - 0-3 настай хүүхдээ асарч байгаа эхээр 15,<br>- Өндөр насны тэтгэвэрт гарсан 11,<br>- Сайн дурын даатгалд хамрагдаагүй, ажил хөдөлмөр эрхлээгүй 146 иргэн байна.<br>Зорилтод бүлгийн эцэг, эхчүүдэд орон нутгийн телевизүүд болон "Дорнод аймгийн нийгмийн даатгалын газар", "Дорнод аймгийн сайн дурын даатгуулагчид" фейсбүүк хуудсаар мөн иргэдрүү утсаар холбогдон мэдээллээр ханган ажилласан. Үүний үр дүнд хагас жилийн байдлаар 82 иргэнтэй гэрээ байгуулан сайн дурын даатгалд хамруулсан байна.<br><br>Цахим хэлбэрээр ирүүлсэн тайланг ажил олгогч байгууллага нь даатгуулагчийн дараах мэдээллийг үнэн зөв мэдээллийн санд бүртгэсэн эсхийг хянан байталгаажуулж ажилласан. Үүнд;<br>• Тушаал, шийдвэрийг үнэн зөв хуулийн дагуу гаргах;<br>• Тушаалыг үндэслэн ажил мэргэжлийн кодыг үнэн зөв сонгож, тайлагнах;<br>• Даатгуулагчийн тохирох төрлийг сонгосон эсэхийг хянах<br>Ажил олгогчийн удирдлагын мэдээлэлийг улсын бүртгэлийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баазаас татаж тулган шалгах. Шаардлагатай тохиолдолд даатгуулагчийн хаягийн мэдээлэл, утасны дугаар, цахим хаяг зэргийг байцаагч даатгуулагчийн хүсэлтийн дагуу баримт бичгийг үндэслэн ***secos*** системд өөрчлөлтийг хийж байна. Жилийн эцсийн байдлаар цаасаар албан хүсэлт гаргасан 12 байгууллагын удирдлаг, нятлан бодогчийн мэдээллийг шинэчлэсэн байна. | | |
| 4 | 3 хүртэл насны хүүхдээ асарч буй эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг өөрөө, 50 хувийг улсын төсөв, тэтгэмжийн даатгалын сангаас хариуцан төлөх хуулийн хүрээнд<br><br>Шимтгэлийг хуулийн хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хууль тогтоомжид | Сайн дурын даатгалд хамрагдсан эхийн тоо | 1057 | Шинээр хамрагдсан 3 хүртэлх насны хүүхдээ асарч буй эхчүүдийн тоо | 3 хүртэлх насны хүүхдээ асарч буй эхчүүдийн оны эхний үлдэгдэлтэй улсын төсвийн 283 эхийн 3.723.551 мянган төгрөг, Тэтгэмжийн даатгалын сангийн 269 эхийн 5.438.286 мянган төгрөгийн өглөгийн мэдээллийг түүвэрлэн сикос системд хөрөвүүлэхэд бэлтэгсэн.<br><br>Шинэ системд 89 эхийн мэдээллийг хуулбарлан баталгаажуулж бүртгэсэн байна. Оны эхнээс хагас жил хүртэл аймгийн хэмжээнд шинээр 105 эх сайн дурын даатгалд хамрагдсан байна.<br><br>Хуулийн хугцаанд тайлангаа илгээгээгүй 55 аж ахуй нэгжтэй утсаар холбогдон хуулийн хугцаанд илгээх талаар мэдээлэл | 2024.01.01<br>-<br>2024.12.30 | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | заасан арга хэмжээ авах<br><br>Зөрчлийн хэрэг бүртгэлтийн үйл ажиллагаа явуулах, шийдвэрлэх | | | | хүргэн ажилласан. Тайлангаа хуулийн хугцаанд илгээх талаар мэдэгдэх хуудсыг 14 аж ахуй нэгжид хүргүүлэхээр бэлтгээд байна.<br><br>Хуулийн хугацаанд нь төлөөгүй 1,325,000 мянган төгрөгийн шимтгэлийн өр төлбөр барагдуулахаар "Улсын байцаагчийн албан шаардлага"-ийг 2 байгууллагад, зөрчлийн хэргийн 8,023,227 мянган төгрөгийн шимтгэлийн өр төлбөр барагдуулахаар 2 байгууллагын холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажилласан байна. | | |
| 5 | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, сайн дурын даатгалын ач холбогдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, "Дорнод сайн дурын даатгуулагчид" пэйж хуудсыг хөгжүүлэх, дагагчдын тоог нэмэгдүүлэх, постер бэлтгэн хуудсанд байршуулах, | Зохион байгуулсан сургалт, сурталчилгаа, хамрагдсан иргэдийн тоо | 15 | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр 4 удаа , 6 постер бэлтгэн, НДЕГ-ын болон холбогдох мэдээллүүдийн түгээх | Дорнод сайн дурын даатгуулагчид /1350 гишүүнтэй/ фейсбүүк группээр дамжуулан шимтгэлийн хэмжээнд орсон өөрчлөлт, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх болон эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх, эсхүл эцэг мөн малчин даатгулагчийн хөнгөлөлтүүдийн талаар. Нийгмийн даатгалын багц хуулийн өөрчлөлт мэдээлэл, сайн дурын даатгал төлөх дансны дугаар, цахимаар хэрхэн хамрагдах боломжуудын талаар 6 постер бэлтгэн байршуулсан, НДЕГ-аас бэлтгэсэн холбогдох 14 мэдээ мэдээлэл хуваалцсанаар нийт 11500 хүн хариу үйлдэл хийж, 37 | 2024.01.01<br>-<br>2024.12.30 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэтгэгдэл, асуулт үлдээн, 50 гаран чатад хариу мэдээлэл өгсөн байна.<br><br>Дорнод-Сайн дурын даатгуулагчид фейсбүүк групп нь өмнөх оны мөн үеэс 270 гишүүнээр нэмэгдсэн байна.<br><br>Мөн хэлтсийн вэб сайтад ирсэн сайн дурын даатгалын талаарх иргэдийн асуултад хариулан шаардлагатай тохиолдолд утсаар нь холбогдон мэдээлэл өгч ажилласан байна. | | |
| ***Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| 1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж, шаардлагатай тохиолдолд ХАСХОМ гаргаж хэвших. | Хэрэгжүүлж ажилласан эсэх | Хуулийн хугацаа | Холбогдох хууль Тогтоомжийн дагуу хийсэн байна. | Хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн. Ажлын байрны чиг үүрэг өөрчлөгдсөнтэй холбоотой https://meduuleg.iaac.mn/AOS/Login системд албан тушаалын өөрчлөлттэй холбоотой цаг үеийн мэдээллийг цахимаар оруулж баталгаажуулсан | | 100 |
| 2 | Нэгжийн чиг үүрэгтэй холбоотой<br>мэдээ, тайлан, судалгаа гаргах,<br>танилцуулах; | Тоо | Тухай бүр | Мэдээ, тайлан, судалгааг үнэн зөв, хугацаандаа гарсан байна | • Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газараас авсан ХБХА байгаа эцэг эхийн нийт 274 иргэний судалгаа<br>• Татварын хэлтэсээс гаргуулсан 3418 аж, ахуйн нэгжийн судалгаа<br>• Журам, аргачлал батлах тухай" А/72 дугаар тушаал,<br>• Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын | 2024.01.01<br>-<br>2024.12.30 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2024 оны "2024 оныг нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай" А/61 дүгээр тушаал, "Болзолт уралдаан зарлах тухай" А/79 дугаар тушаал<br>• НДЕГ-ын даргын 2024 оны "НДС-гийн авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэх тухай" А/64 тоот тушаал<br>• ЖДҮ хөгжүүлэх сангаас зээл авсан аж ахуй нэгжийн судалгаа<br>Тухайн жилд 4 судалгаа 7 мэдээ тайланг хугацаанд нь гарган хэлтсийн даргаар хянуулж хүргүүлсэн. | | |
| 3 | Албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, баримт бичгийн стандартыг хэрэгжүүлж ажиллах, бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу жилийн эцэст архивд хүлээлгэн өгөх; Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах | Хэрэгжүүлж ажилласан эсэх | 2023 онд сайн дурын даатгалын гэрээг 6 хадгаламжийн нэгж үүсгэн архивт | Холбогдох хууль тогтоомжийн дагуу чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, дүрмийг мөрдөн ажиллаж иргэд даатгуулагчаас гаргасан өргөдлийг хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг дагуу ёс зүйн ямар нэгэн зөрчил дутагдал гаргалгүй ажиллаж байна. | 2024.01.01<br>-<br>2024.12.30 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүлээлгэн өгсөн | | | | |
| 4 | Удирдлагын өгсөн үүрэг, даалгавраар ажил гүйцэтгэх, танилцуулах, шаардлагатай тохиолдолд ажил орлон гүйцэтгэх | Хэрэгжүүлж ажилласан эсэх | | Тухай бүр гүйцэтгэж, шаардлагатай тохиолдолд ажил орлон гүйцэтгэсэн байна. | Сайн дурын даатгалын байцаагчийн ээлжийн амралттай байх хугацаанд ажил үүрэгийг түр орлон гүйцэтгэсэн. | 2024.01.01 - 2024.12.30 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Удирдлагаас болон цаг үеийн шинжтэй өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлэн биелэлтийг тайлагнах | Хэрэгжүүлж ажилласан эсэх | | 353,132,105.23 төгрөгийн шимтгэлийн авлага буурсан байна. | Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж авлага барагдуулах аян”-ы удирдамжийн дагуу 1-р багт хуваарилагдан тэтгэмжийн байцаагч Ч.Бямбахишиг, үйл ажиллагааны нягтлан бодогч Танан-Эрдэнэ нартай хамтран 65-н ААН-ийн 353,132,105.23 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулахаар ажиллалаа. 35-н ААН-д улсын байцаагчийн “Албан шаардлага”-ыг биеэр болон цахимаар хүргүүлэн тус албан шаардлагад заасан хугацаанд өр барагдуулаагүй 22 ААН-ийн арилжааны банкан дахь дансыг | 2024.01.01-2024.12.30 | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хаасны үр дүнд 256,525,731.04 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулан ажиллалсан. | | |
| 2 | Газрын даргын тушаалаар томилогдсон тооллогын комиссын бүрэлдэхүүнд ажиллах, | Хэрэгжүүлж ажилласан эсэх | Тухай бүр | Хөрөнгө тоолох ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн үнэн зөв хийсэн байна. | Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2024 оны улсын үзлэг, тооллого явуулах журмын дагуу хэлтсийн даргын 2024 оны тушаалаар тооллогын комиссын бүрэлдэхүүнд орж ашиглалтанд байгаа хөрөнгийг эзэмшиж буй албан хаагч тус бүрээр эд хөрөнгө ашиглалтын карт, хөрөнгийн кодтой тулгалт хийн цаг хугацаанд нь бүртгэж ажилласан. | 2024.01.01-2024.12.30 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдах, | Сургалтад хамрагдсан тоо | 8 | Сургалтад хамрагдсан байна. | НДЕГ-аас зохион байгуулсан нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудад монгол бичгийн чадвар эзэмшүүлэх 10 багц сургалтад хамрагдан монгол бичгийн мэдлэгээ бататгасан.<br>Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүр зохион байгуулдаг сургултаас 7:4:10 “Ес зүйн зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн орчин”, “Стрессийг | 2024.01.01-2024.12.30 | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохицуулахад таны оролцоо", "Бүтээмжээ нэмэгдүүлэх нь", НДЕГ-аас цахимаар зохион байгуулсан "Авлигын шалтгаан, хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр комиссар Р.Төрбулаг, "Авлигын гэмт хэрэг, түүний ойлголт" сэдвээр комиссар М.Жамъяачойжил нарын сургалт зэрэг сургалтуудад хамрагдсан. | | |
| 2 | Төрийн албан хаагчийн болон Нийгмийн даатгалын байцаагчийн мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд санаачлагатай хандах | Сургалтад хамрагдсан тоо | 18БЦ | Сургалтад хамрагдсан байна. | Төийн албан хаагчийн болон байцаагчийн мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, хууль тогтоомжийн мэдлэг чадвараа дээшлүүлэх үүднээс МУИС-ийн хууль зүйн сургуулийн эчнээ хөтөлбөрт хамрагдан 2 дугаар дамжаагаа амжилттай дүүргээд байна. | 2024.01.01-2024.12.30 | 80 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ХАМРАЛТ ОРЛОГО ШИМТГЭЛИЙН ӨР ХАРИУЦСАН БАЙЦААГЧ
*( Албан тушаал )*

................................ / М.Энхцэцэг /
*( Нэр, гарын үсэг )*

2024.12.17
*( Огноо )*